



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/733

Зуунмод

Газрын дуудлага худалдааны
орлого хуваарилах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2022 онд газрын дуудлага худалдаанаас төрийн сангийн газрын биржийн (100140000967) тусгай дансанд орсон орлогыг 2022 оны 10 дугаар сарын 01-ээс 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон хуваарилж сумдын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 50 хувийг нэгдүгээр, аймгийн нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 40 хувь, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 10 хувийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Газрын дуудлага худалдаанаас хуваарилагдсан орлогыг зарцуулахдаа Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг баримтлан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б.Одгун шувуу.
Мурлын зүүн хэсэгт
хотон санхүүгээр.
Алсан

Аймгийн Засаг даргын 2022 оны
А/733 12 дугаар сарын 15 -ны өдрийн
дугаар захирамжийн / дүгээр хавсралт



Газрын дуудлага худалдааны орлогын хуваарь

№	Сумдын нэрс	Газрын дуудлага худалдааны орлого өссөн дүнгээр	Сумдын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэх 50 хувь /мян.төг/
1	Аргалант	2000	1000.0 ✓
2	Батсүмбэр	3471.98	1736.0 ✓
3	Баяндэлгэр	13960	6980.0 ✓
4	Баянцогт	5040.01	2520.0 ✓
5	Баянчандмань	214120	107060.0 ✓
6	Борнуур	89506.83	44753.4 ✓
7	Лүн	960.0	480.0 ✓
8	Мөнгөнморьт	26971.85	13485.9 ✓
9	Сэргэлэн	467516.6	233758.3 ✓
10	Цээл	6113.58	3056.8 ✓
11	Эрдэнэ	5100	2550.0 ✓
12	Эрдэнэсант	1450	725.0 ✓
13	Зуунмод	4510	2255.0 ✓
	дүн	840720.9	420360.4 ✓